



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/204

Булган сум

**“Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох
сургалтыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7, дахь хэсэг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 32 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2025 оны А/43 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтыг 04 дүгээр сарын 01-нээс 08 дугаар сарын 16-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулахыг Цэргийн штаб (дайчилгааны офицер хошууч Ц.Цэрэнтогтох)-т үүрэг болгосугай.

2.“Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах оюутан, суралцагчдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах нарийн мэргэжлийн эмч нарын комисс гарган ажиллуулахыг Эрүүл мэндийн газар (П.Оюунцэцэг)-т, цэргийн ерөнхий бэлтгэл сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлийн байр, техник хэрэгслээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Наранбаяр)-т тус тус даалгасугай.

3.Сургалтад шаардагдах 823,000 (найман зуун хорин гурван мянга) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Наранбаяр)-т зөвшөөрсүгэй.

4.“Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан 2025 оны 3 дугаар улиралд багтаан танилцуулахыг Цэргийн штаб (дайчилгааны офицер хошууч Ц.Цэрэнтогтох)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 20²⁵ оны
03 дугаар сарын 31.-ны/ний өдрийн А/204/ дүгээр
захирамжийн хавсралт

ЗАРЦУУЛАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

д/д	Зардлын чиглэл	Хөрөнгийн хэмжээ	Тайлбар
1	2	3	4
1	Сургалтын материал	445,000	Дэвтэр-20ш*3000=60000 Бал 20ш*3000=60000 “Оюутан-цэрэг” сургалтын суралцагчдад зориулсан гарын авлага 10ш*30000=300,000 Хичээлийн журнал-1ш*25000=25000
2	Шатахуун	378,000	Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн сургалтын төвд хүргэж өгөх, буцааж авах
Бүгд			823,000